



ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

**АЙМАГ, СУМЫН ИТХ-ЫН СОНГУУЛЬД ОРОЛЦСОН НАМ, ЭВСЛИЙН
СОНГУУЛИЙН ЗАРДЛЫН ТАЙЛАН**

Цахим хуудас: www.audit.mn

Орхон аймаг

2024 он

АГУУЛГА

НЭГ. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ	3
1.1 Аудитын нэр	3
1.2 Аудит хийх бүрэн эрх, үндэслэл	3
1.3 Үндэслэл, зорилго	3
1.4 Хамрах хүрээ	3
1.5 Арга зүй	3
ХОЁР. СОНГУУЛИЙН ЗАРДЛЫН САНХҮҮЖИЛТ	4
2.1 Сонгуулийн зардлын дансны мэдээлэл	4
2.2 Сонгуулийн зардлын санхүүжилт	4
ГУРАВ. СОНГУУЛИЙН ЗАРДЛЫН ТАЙЛАН	5
3.1 Төрийн аудитын байгууллагад ирүүлсэн сонгуулийн зардлын тайлан	5
3.2 Сонгуулийн зардлын тайлан баталгаажуулалт, тайлагнал	5
ДӨРӨВ. НЭГ САЯ БА ТҮҮНЭЭС ДЭЭШ ТӨГРӨГИЙН ХАНДИВ ӨГСӨН ИРГЭН, ХОЁР САЯ БА ТҮҮНЭЭС ДЭЭШ ТӨГРӨГИЙН ХАНДИВ ӨГСӨН ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН МЭДЭЭЛЭЛ	6
4.1 Нэг сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн иргэн, хоёр сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн хуулийн этгээдийн талаар	6
ТАВ. ДҮГНЭЛТ	6

Хавсралтын жагсаалт

Хавсралт 1. Аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцсон нам, эвсэлд нэг сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн иргэн, хоёр сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн хуулийн этгээдийн жагсаалт

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АНСДИТХСТХ	Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
НББТХ	Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль

НЭГ. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

1.1 Аудитын нэр:

Аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцсон нам, эвслийн сонгуулийн зардлын тайланг хянаж, олон нийтэд мэдээлэх.

1.2 Аудит хийх бүрэн эрх, үндэслэл:

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.1-д заасны дагуу “Аудитын сэдэв батлах тухай” Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2023 оны 8 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2024 оны А/24, А/44 дүгээр тушаалыг тус тус үндэслэн аудитыг гүйцэтгэсэн.

1.3 Үндэслэл, зорилго:

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.1-д “Төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллага зардлын тайланг хүлээн авсан өдрөөс хойш 60 хоногийн дотор хянаж, дүнг нийтэд мэдээлэх бөгөөд нэг сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн иргэн, хоёр сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн хуулийн этгээдийг нийтэд мэдээлнэ” гэж заасны дагуу Орхон аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцсон нам, эвслийн сонгуулийн зардлын тайланг хянаж нэгтгэн, дүнг холбогдох эрх бүхий байгууллага, албан тушаалтанд хүргүүлж, нийтэд мэдээллээ.

1.4 Хамрах хүрээ:

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцсон нам, эвслийн аудитын хуулийн этгээдээр баталгаажуулан ирүүлсэн сонгуулийн зардлын тайлан, аудитын дүгнэлт, харилцагч банкны дансны хуулга бусад шаардлагатай баримт, материалуудыг хамруулсан.

Тус сонгуульд нийт 5 нам оролцсон бөгөөд төрийн аудитын байгууллагад 2 нам сонгуулийн зардлын тайлангаа аудитын хуулийн этгээдээр баталгаажуулан ирүүлсэн байна.

Арилжааны банкнудаас Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.5¹-д заасны дагуу нам, эвслийн сонгуулийн зардлын дансны хуулгыг ирүүлсэн байна.

1.5 Арга зүй:

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын дарга тэргүүлэх аудиторов 2024 оны 10 дугаар сарын 11-ний өдрийн А/10 дугаар тушаалаар баталсан “Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох нам, эвсэл, нэр дэвшигч сонгуулийн зардлын тайлан гаргах, зардлын тайланд аудит хийх, хянах, дүнг нийтэд мэдээлэх, танилцуулах журам”-ыг мөрдлөг болгож сонгуулийн зардлын тайланг хянах, нотлох баримтыг нягтлан шалгах, тулган баталгаажуулах, лавлагаа авах арга зүйг ашигласан.

¹ 56.5 Сонгуулийн зардлын данс байршуулсан банкны захирал, эсхүл салбарын эрхлэгч уг дансны бүх гүйлгээний хуулгыг гаргаж, санал авах өдрөөс хойш 30 хоногийн дотор төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллагад хүргүүлнэ

ХОЁР. СОНГУУЛИЙН ЗАРДЛЫН САНХҮҮЖИЛТ

2.1 Сонгуулийн зардлын дансны мэдээлэл

Төрийн аудитын байгууллагад Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.3²-д заасны дагуу сонгуулийн зардлын дансны дугаар, банкны нэрийн мэдээллийг сонгуульд оролцсон 5 нам бүртгүүлэхээс 2 нам бүртгүүлж, 3 нам данс нээгээгүй байна.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.3³-д заасны дагуу 5 нам сонгуулийн зардлын зарцуулалтын тайлан ирүүлэхээс 2 нам ирүүлж, 3 нам ирүүлээгүй байна.

Тайлан ирүүлээгүй 3 намын 1 нь сонгуулийн зардлын данс нээлгээгүй талаар мэдэгдэл төрийн аудитын байгууллагад ирүүлсэн бол 2 нам сонгуулийн мөрийн хөтөлбөр хянуулахаар ирүүлэхдээ холбогдох тайлбарыг ирүүлсэн.

2.2 Сонгуулийн зардлын санхүүжилт

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцсон нам, эвслээс сонгуулийн зардлын тайлангаа ирүүлсэн 2 намын данс эхний үлдэгдэлгүй байна. Сонгуульд оролцсон нам нийт 65,470.4 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 65,470.0 мянган төгрөгийг сонгуулийн үйл ажиллагаанд зарцуулж, харилцах дансны үлдэгдэл 0.4 мянган төгрөг, өр төлбөрийн үлдэгдэлгүй тайлагнасан байна.

Сонгуульд оролцсон нам, эвсэлд 32 иргэн 63,650 мянган төгрөг, нам 1,820.4 мянган төгрөг, нийт 65,470.4 мянган төгрөгийн мөнгөн хандив өгсөн байна.

Санхүүжилт

Нам, эвслийн сонгуулийн зардлын тайлангаарх нийт орлого 65,470.4 мянган төгрөгийг орлогын ангиллаар харуулбал. Үүнд:

Хүснэгт 1. Сонгуулийн зардлын санхүүжилт, эх үүсвэр

/мянган төгрөг/

Орлогын ангилал	Тоо	Мөнгөн хандивын дүн
Нам, эвслээс оруулсан мөнгөн хөрөнгө	2	1,820.4
Хуулийн этгээдийн хандив	-	-
Иргэний хандив	32	63,650.0
Дүн	34	65,470.4

Иргэнээс нэг сая ба түүнээс дээш төгрөгийн 63,650.0 мянган төгрөгийн хандив авсныг Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.1⁴-т заасны дагуу нийтэд мэдээллээ.

² 50.3.Нам, эвсэл болон нэр дэвшигч нь сонгуулийн зардлын дансны дугаар, банкны нэрийг санал авах өдрөөс 20-оос доошгүй хоногийн өмнө төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллагад мэдэгдэж, бүртгүүлэх үүрэгтэй.

³ 56.3.Нам, эвсэл нь санал авах өдрөөс хойш 45 хоногт, нэр дэвшигч санал авах өдрөөс хойш 30 хоногт багтаан зардлын тайландаа хувийн аудитын хуулийн этгээдээр дүгнэлт гаргуулан, төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллагад хүргүүлнэ.

⁴ 57.1.Төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллага зардлын тайланг хүлээн авсан өдрөөс хойш 60 хоногийн дотор хянаж, дүнг нийтэд мэдээлэх бөгөөд нэг сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн иргэн, хоёр сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн хуулийн этгээдийг нийтэд мэдээлнэ.

ГУРАВ. СОНГУУЛИЙН ЗАРДЛЫН ТАЙЛАН

3.1 Төрийн аудитын байгууллагад ирүүлсэн сонгуулийн зардлын тайлан

Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын 2024 оны 6 дугаар сарын 28-ны өдрийн А/04 дүгээр тушаалаар Аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд нам, эвслээс зарцуулах зардлын дээд хэмжээг 468,378.5 мянган төгрөгөөр тогтоосон ба сонгуульд оролцсон нам, эвслүүд тогтоосон хэмжээнд зардал гаргасан байна.

Зардал

Намууд сонгуулийн үйл ажиллагааны зардалд нийт 67,470.0 мянган төгрөг зарцуулснаас сонгуулийн зардалд 65,467.0 мянган төгрөг, бусад зардалд 2,003.0 мянган төгрөг зарцуулжээ. Үүнд:

Хүснэгт 2. Сонгуулийн зардлын гүйцэтгэл /мянган төгрөг/

Зардлын ангилал		Мөнгөн дүн
НИИТ ЗАРДЛЫН ДҮН		67,470.0
2.1 Сонгуулийн зардал		65,467.0
2.1.1 сонгуулийн сурталчилгааны материал хэвлүүлэх, сонгогчдод тараах		47,700.0
2.1.2 нийтийн эзэмшлийн гудамж, талбайд сонгуулийн сурталчилгааны зурагт самбар, дэлгэц байрлуулах зардал		0.0
2.1.3 намын далбааг гудамж талбайд байршуулах, таних тэмдэг, уриа ашиглах зардал		1,000.0
2.1.4 сонгогчидтой уулзалт, хурал, цуглаан хийх зардал		0.0
2.1.5 сонгууль эрхэлсэн байгууллагын үйл ажиллагааны зардал		0.0
2.1.6 сонгуулийн сурталчилгаанд радио, телевиз ашиглах		0.0
2.1.7 цахим орчин ашиглах зардал		15,947.0
2.1.8 өдөр тутмын болон бусад сонин сэтгүүлд материал нийтлүүлэх зардал		820.0
2.2 Бусад зардлын дүн		2,003.0

Өр төлбөр

Сонгуулийн зардлын тайланд өр төлбөрийн үлдэгдэлгүй байна.

Хуулиар зөвшөөрөгдөөгүй хандив

Хандив өгч байгаа иргэний нэр, иргэний бүртгэлийн дугаар, хуулийн этгээд нь нэр, регистрийн дугаар болон хандивын эх үүсвэрийн талаарх мэдээллээ банкны гүйлгээний баримтад тусгаагүй 2,000.0 сая төгрөгийн хандивыг хандивлагчид буцаан шилжүүлсэн байна.

3.2 Сонгуулийн зардлын тайлан баталгаажуулалт, тайлагнал

Төрийн аудитын байгууллагад 2 аудитын хуулийн этгээд Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын дарга тэргүүлэх аудиторын 2024 оны 10 дугаар сарын 11-ний өдрийн А/10 дугаар тушаалаар баталсан “ Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох нам, эвсэл, нэр дэвшигч сонгуулийн зардлын тайлан гаргах, зардлын тайланд аудит хийх, хянах, дүнг нийтэд мэдээлэх, танилцуулах журам”-ын дагуу сонгуулийн зардлын тайланг баталгаажуулан ирүүлсэн байна.

ДӨРӨВ. НЭГ САЯ БА ТҮҮНЭЭС ДЭЭШ ТӨГРӨГИЙН ХАНДИВ ӨГСӨН ИРГЭН, ХОЁР САЯ БА ТҮҮНЭЭС ДЭЭШ ТӨГРӨГИЙН ХАНДИВ ӨГСӨН ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН

МЭДЭЭЛЭЛ

4.1 Нэг сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн иргэн, хоёр сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн хуулийн этгээдийн талаар

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.1⁵-д заасны дагуу төрийн аудитын байгууллагаас нэг сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн иргэн, хоёр сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн хуулийн этгээдийн мэдээллийг нэгтгэлээ.

Үүнд нийт 32 иргэн 63,650.0 мянган төгрөгийн нэг сая ба түүнээс дээш төгрөгийн мөнгөн хандивыг намд өгсөн байна.

Төрийн аудитын байгууллагаас иргэн, хуулийн этгээдээс өгсөн дээрх мөнгөн хандивын мэдээллийг audit.mn сайтад байршуулж, нийтэд ил тод мэдээллээ.

ТАВ. ДҮГНЭЛТ

Сонгуульд оролцсон намын сонгуулийн зардлын тайланг аудитын хуулийн этгээдүүд баталгаажуулан, үнэн зөв, иж бүрэн илэрхийлэгдсэн гэж дүгнэлт гарган Төрийн аудитын байгууллагад газарт ирүүлсэн боловч аудитаар хянахад сонгуулийн зардлын данс нээхгүй байх, данс нээлгэсэн ч орлого, зардал гараагүй зэрэг хуульд нийцээгүй зөрчлийг илрүүлэхгүй байгаа ба хариуцлагын талаар хуулийн зохицуулалт байхгүй байна.

Төрийн аудитын байгууллага 32 иргэнээс нэг сая ба түүнээс дээш төгрөгийн 32 иргэн 63,650.0 мянган төгрөгийн хандив авсныг Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.1-т заасны дагуу нийтэд мэдээлсэн.

Сонгуульд оролцсон нам нийт 65,470.4 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 67,470.0 мянган төгрөгийг сонгуулийн үйл ажиллагаанд зарцуулж, харилцах дансны үлдэгдэл 0.4 мянган төгрөг, төлөгдөөгүй өр төлбөрийн үлдэгдэлгүй тайлагнасан байна.

⁵ 57.1.Төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллага зардлын тайланг хүлээн авсан өдрөөс хойш 60 хоногийн дотор хянаж, дүнг нийтэд мэдээлэх бөгөөд нэг сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн иргэн, хоёр сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн хуулийн этгээдийг нийтэд мэдээлнэ.

Хавсралт 1

Аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд ороцсон нам, эвсэлд нэг сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн иргэн, хоёр сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн хуулийн этгээдийн жагсаалт

№	Нам, Эвслийн нэр	Хандив өгсөн иргэн болон хуулийн этгээдийн нэр	Мөнгөн хандивын дүн	
			Иргэн /Нэг сая төгрөгөөс дээш/	Хуулийн этгээд /Хоёр сая төгрөгөөс дээш/
1	Монгол Ардын нам	Х.Одгэрэл	2,000,000.00	
2	Монгол Ардын нам	Т.Мягмарсүрэн	2,000,000.00	
3	Монгол Ардын нам	Г.Цоодол	2,000,000.00	
4	Монгол Ардын нам	Д.Бүрэнжаргал	2,000,000.00	
5	Монгол Ардын нам	Ш.Долзодмаа	2,000,000.00	
6	Монгол Ардын нам	Л.Батгэрэл	1,960,000.00	
7	Монгол Ардын нам	Б.Амарболд	2,000,000.00	
8	Монгол Ардын нам	Б.Гэрэлмаа	2,000,000.00	
9	Монгол Ардын нам	Д.Нармандах	2,000,000.00	
10	Монгол Ардын нам	Б.Уранчимэг	2,000,000.00	
11	Монгол Ардын нам	А.Одгэрэл	2,000,000.00	
12	Монгол Ардын нам	Э.Зодвоо	2,000,000.00	
13	Монгол Ардын нам	Д.Баттогтох	2,000,000.00	
14	Монгол Ардын нам	Б.Түвшинтөгс	2,000,000.00	
15	Монгол Ардын нам	П.Ариунжаргал	2,000,000.00	
16	Монгол Ардын нам	Л.Батцэцэг	2,000,000.00	
17	Монгол Ардын нам	Д.Энхцэцэг	2,000,000.00	
18	Монгол Ардын нам	З.Алтанцэцэг	2,000,000.00	
19	Монгол Ардын нам	Э.Түмэнбаяр	2,000,000.00	
20	Монгол Ардын нам	Б.Ганзул	2,000,000.00	
21	Монгол Ардын нам	О.Баярбат	2,000,000.00	
22	Монгол Ардын нам	Э.Золбоо	2,000,000.00	
23	Монгол Ардын нам	Б.Хатанбаатар	2,000,000.00	
24	Монгол Ардын нам	Д.Батлут	1,690,000.00	
25	Монгол Ардын нам	Н.Эрдэнэдаваа	2,000,000.00	
26	Монгол Ардын нам	Б.Чогсомжав	2,000,000.00	
27	Монгол Ардын нам	Б.Наранжаргал	2,000,000.00	
28	Монгол Ардын нам	А.Ариунтамир	2,000,000.00	
29	Монгол Ардын нам	М.Өлзийбаяр	2,000,000.00	
30	Монгол Ардын нам	Э.Түвшинтөр	2,000,000.00	
31	Монгол Ардын нам	Б.Мөнхцэцэг	2,000,000.00	
32	Монгол Ардын нам	Э.Энхтайван	2,000,000.00	
Нийт дүн			63,650,000.00	0.00